



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/699

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Аймгийн Онцгой комиссын 28 тоот тогтоол, Засгийн газрын 2020 оны Төв суурин газрын 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай 69 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор, ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нөөцөд 2020-2021 оны тэжээл бэлтгэн нийлүүлэхээр шууд гэрээ байгуулан ажиллаж байгаа "Хос алтайн бүрд" ХХК-д гэрээний дагуу 30.0 сая төгрөгийг олгосугай.
2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 30.0 сая төгрөг/гучин сая/-ийг аймгийн өвс, тэжээлийн нөөцийн санхүүжилтээс олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.
3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

